



# ТАРХИНЫ СААЖИЛТАЙ ХҮҮХДИЙН АСАРГААНЫ ТАРЫН АВЛАГА - ХӨДӨЛГӨӨН -

Боловсруулсан: Мориши Марико (хөдөлгөөн засалч)



Нинжин ТББ

Энэхүү гарын авлагыг тархины саажилттай хүүхдийг өсгөхдөө хүүхдийн хөгжил, хөдөлгөөнийг аль болох зөв удирдан чиглүүлж, хүүхдэд таатай орчин нөхцлийг бүрдүүлснээр өдөр тутмын амьдралд нь эерэг өөрчлөлтийг авчрах зорилгоор эцэг эх, асран хамгаалагчдад зориулан гаргаж буй юм.

Тархины саажилттай хүүхдүүд нь эрүүл хүүхэдтэй адилхан хэвтэх байрлалаа өөрөө сольж, өөрөө суух зэргээр хөдөлгөөний хөгжил нь аяндаа явагдахгүй. Бас дээрээс нь ойр орчимд нь байгаа сонирхол татсан зүйлийг өөрөө дураараа очиж аваад оролдож үзэж, тоглож наадаж чадахгүй.

Хөдөлгөөний чадавхи гэдэг бол хооллох, ундлах, мөлхөх, суух, тоглож наадах, босч зогсох, алхах гээд өдөр тутмын энгийн үйлдлүүдийг бие даан хийх чадвар бөгөөд энэ нь хүүхдийн өдөр тутмын амьдралд эерэг өөрчлөлт, ахиц дэвшлийг авчирч байдаг.

Үүнээс дүгнэж үзвэл хүүхдийн асаргааны үндсэн зорилго нь хөдөлгөөн нэг бүрийг нь хөгжилтэй нь уялдуулж, цаашид бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх, зөв зохистой удирдан чиглүүлэх явдал юм.


Эрүүл хүүхэдтэй адил түвшинд сурах боломжгүй ч “Хүүхэд болгон өөр өөрийн гэсэн онцлогтой гэдгийг үргэлж санаж” хүүхэд бүрт тохирсон аргаар бага багаар дадлагажуулан сургаж эзэмшүүлэхийг зорих нь чухал юм.

Энэхүү гарын авлагад эцэг эх, асран хамгаалагчид нь хүүхдээ асрахдаа юуг анхаарах, ямар аргачлал хэрэглэх нь тохиромжтой талаар тусгаж өгсөн билээ. Тохирсон аргачлал, зохистой хөдөлгөөний тусламжтайгаар хүүхдийн хөдөлгөөний чадавхи нь сайжирч цаашдын өсөлт хөгжилд нь эерэг нөлөө үзүүлээсэй хэмээн хүсч байна.

## 1) Хүүхдийг хэвтүүлэх арга

Хүүхдийг тэвэрч байгаад хэвтүүлэх үед толгой нь унжиж, нуруугаараа арагшаа нумарч гэдийдэг. Тэгвэл хүүхдийг хэвтүүлэхэд хамгийн тохиромжтой аргуудыг сураад аваарай.


1. Хүүхдийн толгойг бага зэрэг доош нь гилжийлгэн, баруун эсвэл зүүн хажуугаар тэврэх.



Зураг 1

*Хүүхдийг ингэж тэврэх нь толгойг тогтвортой болгож, арагшаа нумарч гэдийхээс сэргийлдэг*


2. Хажуу тийш харуулан хэвтүүлж, ууц болон өвдөгний үеэр нь бага зэрэг нугалж өгнө.



Зураг 2.

*Ингэж хэвтүүлвэл хүүхдийн нуруу арагшаа нумарч гэдийхгүй*

3. Зөөлхөн эргүүлж дээш харуулна.
4. Бие нь арагшаа гэдийж, нумраад байвал толгой доор нь дэр тавьж бага зэрэг бөхийлгөөд өвдөгний үеэр нь нугалж ивээс хийж өгөөрэй



Зураг 3


5. Дээшээ харж хэвтэхдээ нүүрээ аль нэг тал руугаа харуулж, гараа алдалж, хөлөө өвдгөөр нь дэлгэж хэвтдэг бол (Зураг 4 – а, б) Эсрэг тал руу нь харуулж хажуугаар нь хэвтүүлээрэй




а. Нүүрээ үргэлж баруун тал руугаа харуулж хэвтдэг



с. Зүүн хажуугаар нь хэвтүүлэх байрлалыг сонгоно



б. Нүүрээ үргэлж зүүн тал руугаа харуулж, өвдгөө дэлгэж хэвтдэг




д. Баруун хажуугаар нь хэвтүүлж тэврүүлдэг дэрийг урд талд нь ивж өгөх

Зураг 4

6. Гэрийн дотор ор тавих тохиромжтой байршил: Нүүрээ үргэлж нэг тал руугаа харуулж хэвтдэг бол (Жишээ нь баруун тал руугаа)


Хүүхэд хэвтэж байхдаа хаалга болон, цонхоор тусч буй гэрлийг чөлөөтэй харж байхуйцаар орны байрлалыг сонгох нь тохиромжтой. Энэ нь хүүхэд хэвтэж байхдээ хаалгаар хэн нэгэн орж ирэхийг заавал харахыг хүсдэгтэй нь холбоотой юм. Зураг – 5 а,б



а. Орны тохиромжтой байрлал: Гэрийн дотор



б. Хүүхдийн өрөө Хаалга нээгдэхэд хүүхэд арагшаа эргэж харах гэж оролддог



с. Орны тохиромжгүй буруу байрлал

Орыг хаалга руу харуулж тавихгүй бол хүүхэд хүн орж ирэх бүрт нь өндийж, эргэж харах гэж оролддог. Мөн нүүрээ үргэлж баруун тал руугаа харуулж хэвтдэг хүүхдийн орны байрлалыг буруу сонгосноос багана нуруу болон гуяны ясны хэлбэр өөрчлөгдөх эрсдэлтэй.

## 2) Өргөж босгох арга

Хүүхдийг дээшээ харж хэвтэж байхад нь шууд толгойг нь гараараа тулж өндийлгөх, өргөх зэрэг нь хүүхдийг арагш нь гэдийлгэж хүзүүний булчингийн хөгжилд нь саад учруулдаг.

Хүүхдийг өндийлгөх, өргөж босгох хамгийн тохиромжтой арга юу вэ?



Зураг 6

1. Дээшээ хараад хэвтэж байгаа хүүхдийг эхлээд хэвтрийн байрлалыг нь сольж хажуугаар нь хэвтүүлсний дараа нэг гараа суган доогуур оруулж, нөгөө гараараа гэдсээр нь тэвэрч өргөнө. (a,b)
2. Солгой гартай хүмүүсийн хувьд хүүхдийнхээ хүзүү, ууц нуруу, өвдөгний үеэр нь нугалж, мөр хүзүүгээр нь тэвэрч өргөнө. (c)

Энэ аргаар өндийлгөж, өргөх нь хүүхдэд өөрөө толгойгоо өргөх боломжийг олгодог. Мөн гэдийх шаардлагагүй учраас хүүхдийн биед илүү ая тухтай байдаг.

## 3) Тэврэх арга

Хүүхдийн толгой тогтворгүй, бие нь чангаралтай, эсвэл булчин султай зэргээс шалтгаалаад тэврэхэд бэрхшээлтэй байх нь бий. Хүүхэд бүрийн онцлогоос шалтгаалаад тэврэх арга нь өөр өөр байдаг.

1. Толгой нь тогтворгүй, бие нь чангаралтай хүүхдийн хувьд
  - a. Нэг гарын бугуйгаар хүүхдийнхээ толгой, хүзүүг тулж гарыг нь аль болох урагш тэнийлгэж сунгаж өгөх маягаар өвөр дээрээ суулгаж тэврэнэ.
  - b. Хүүхдийг доош нь харуулж, нэг гараа хоёр суган доогуур нь хийж, нөгөө гараа хоёр хөлнийх нь завсраар хийн гэдэснээс нь тулж тэврэнэ.

Хүүхдээ ийм байдлаар тэврэх нь толгойгоо өргөх боломж олгохоос гадна биеийн сунгалтын дасгал болдог байна.

2. Толгой нь тогтворгүй, хөнгөн хэлбэрийн атетозтой (\*1) хүүхдийн хувьд
  - с. Хүүхдээ түрүүлгээ харуулан нэг гараа цээжин доогуур оруулж, нөгөө гараараа түнх ба өвдөгний үеэр нь нугалж тэврэнэ. Энэ арга нь хүүхдэд гараа урагш гаргах болон тэнцвэрээ олох боломжийг бүрдүүлж өгдөг.
3. Атетоз (эмгэг хөдөлгөөнтэй) болон Хипотониа (булчин суларсан) ТС-тай (\*2) хүүхдийн хувьд
  - д. Хүүхдийнхээ хоёр хөлийг нийлүүлж, гараараа хоёр гарыг нь урагшлуулж өвдгийг нь ороох маягаар тэврэнэ. Нурууг нь биедээ сайтар наалдуулж, түшиж өгнө.
4. Толгой нь тогтвортой боловч, арагшаа гэдийдэг, доод мөчдийн чангаралттай хүүхдийн хувьд
  - е. Хүүхдийнхээ хоёр хөлийг дэлгэн, өвдгөөр нь нугалж, өөрийгөө хүзүүдүүлэн тэврэнэ.



a.



b.



c.



d.



e.

Зураг 7

5. Хүйтэн үед эсвэл эмнэлэгт үзүүлэхээр явахдаа хүүхдээ өлгийдөж тэвэрдэг үү



Зураг 8

Хүүхдийн хөлийг хөдөлгөөнгүй тэнийлгэн өлгийдөж удаан байлгах нь түнхний мултрал үүсгэх эрсдэлтэй.

Хэрэв түнхний мултралтай болчихвол хүүхдийн хөдөлгөөний хөгжил (суух, мөлхөх, юм түшиж зогсох г.м) нь хэвийн явагдахгүй бөгөөд үүнээс шалтгаалан бусад хүндрэлүүд ч дагалдан гарах юм.

Хүүхдээ энгэртээ нааж тэврэх нь тохиромжтой. Зайлшгүй өлгийдөх шаардлагатай бол хүүхдийн хөл өлгийн дотроо М хэлбэртэй буюу өвдөг болон түнхний үеэрээ чөлөөтэй нугарч байхаар тооцоолж сулхан өлгийдөөрэй.



Зураг 9

Энгэртээ тэврэх


Хүүхдээ цээжиндээ нааж, хоёр хөлийг нь М үсэг хэлбэрээр дэлгэж тэврэнэ



Зураг 10

Өлгийдөж тэврэх

Хөл нь М хэлбэрээ хадгалан өлгийдөө чөлөөтэй байхаар сулхан өлгийдөж тэврэнэ.



Зураг 11

Зориулалтын үүргэвч ашигласан байдал

Өлгийг нь тойруулж уяхдаа дараах зүйлсийг анхаарах нь чухал.

- Хүүхдийн уцны ясны дээд талаар уях
- Хөл нь хөдөлж байхуйцаар сулхан уях

#### 4) Хүүхдийг бие даан сууж сургахад чиглэгдсэн аргачлал

##### 1. Өвдөг дээрээ суулган тэврэх

Хэрвээ хүүхэд уйлагнах, тавгүйдэх зэргээр тайвшрахгүй байвал ярих, дуртай дууг нь дуулах зэргээр анхаарлыг нь татах хэрэгтэй. Зураг а.

Тэгээд ч тайвширч, тогтвортой сууж чадахгүй байвал хүүхдийнхээ цээжин дээр нь алгаараа дарж, хүндийн жинг нь суудал яс руу төвлөрүүлэх маягаар тайвшруулж болно. Зураг б.

Тав тухтай, эвтэйхэн байвал хүүхэд аяндаа тайвширч инээж, ярьж, гараа хөдөлгөж тоглодог.



Зураг 12. Тэврээд, ярьж тайвшруулаарай




Зураг 13. Цээжин дээр нь алгаараа дарж, хүндийн жинг нь суудал яс руу төвлөрүүлэх

##### 2. Хүүхдийнхээ хөлийг дэлгэж, өвдгийг тэнийлгэн шалан дээр суулгах арга

Шалан дээр суулгах үед ч бас хүүхдийн биеийн хүндийн жин нь суудал ясан дээр төвлөрч байх ёстой. Зураг а.

Зөвхөн хоёр мөрнөөс нь тулах маягаар, шалан дээр суухад нь туслах. Зураг б.

Хүүхдийн цээжин бие болон ууц нуруунаас нь тулах маягаар суухад нь туслах. Зураг с.



Зураг 14.



Зураг 15.



Ингэж суулгаж байхдаа хүүхдийн хөдөлмөөр байгаа тал руу нь хамт хөдөлж, буцаж эргэх үед нь дагаж эргэх маягаар биеэ чөлөөтэй хөдөлгөхөд нь туслах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хүүхэддээ өөрийнхөө хүчээр босоод сууж байгаа мэт таатай мэдрэмжийг төрүүлэхийг хичээгээрэй.



Зураг 16.

3. Хүүхдийг сандал ашиглан суулгах аргачлал

Суухад нь бусдын тусламж, асаргаа шаардлагатай хүүхдийн хувьд, ээж нь байнга тэврээд сууж байх боломжгүй байдаг. Тиймээс хүүхэд суухад тохиромжтой сандал байвал, ээж нь хүүхдээ хажуудаа суулгачаад гэрийн ажилаа чөлөөтэй хийж болох юм.

Тэгвэл таны хүүхдэд ямар сандал хамгийн тохиромжтой байх вэ? Энэ нь таны хүүхдийн ямар байрлалтай суудгаас хамаараад өөр өөр байна.

1) Хүүхдийн толгой сул, цээжин биеэ дугуйруулж суудаг хүүхдийн хувьд

- Толгой болон цээжин биеийг нь тулж байхаар, бага зэрэг налуу түшлэгтэй сандал хамгийн тохиромжтой. (a)
- Цээжин бие нь аль нэг тал руугаа хазайгаад байвал, суганаас нь доош сандал хүртэл нь ивээс хийж өгнө. (b)



Зураг 17.



Зураг 18.

2) Бие нь чангаралтайн улмаас сандалд суух үедээ нумарч гэдийдэг хүүхдийн хувьд

Түнхний үеэрээ чөлөөтэй нугарч байхуйцаар гуян доогуур нь алчуур ивж, дэлгэж өгнө. Сандалын түшлэг нь арагшаа налуу байх ёстой. (c)

Хөл нь нилээд чангаралтай, үзүүр хэсгээрээ зөрдөг бол гуяных нь завсар алчуур хавчуулж, хөлийн ул нь шал буюу сандалын гишгүүрт хүрч байхуйцаар, шилбэний хэсгийг нь бүчээр тогтоож суулгана.  
(d)



Зураг 19. Гуян доор нь алчуур ивж өгөх



Зураг 20. Гуяных нь завсар алчуур хавчуулах  
Шилбэний хэсгийг бүчээр тогтоох

(с) Зориулалтын сандал: Япон 30 орчим жилийн өмнөөс мэргэжлийн техникчид үйлдвэрлэж байна



Зураг 21




Зураг 22

4. Өөрөө бие даан сууж чаддаг боловч, хөлөө байнга W хэлбэртэй тавьж суудаг хүүхдийн хувьд

Ингэж буруу сууснаас болж, түнхний үенд эмгэг өөрчлөлт гарч, цаашид зогсох, явах хөдөлгөөн хийх үед өвдөг нь тэнийхгүй, өвдөгөө хавирах, өсгий нь газарт хүрэхгүй, өлмийгөөрөө дотогшоо гишгэх зэрэг олон асуудал үүсдэг.



Зураг 23



Зураг 24


Тиймээс W хэлбэртэй суулгахын оронд тохирсон сандалд нь зөв суулгахыг зөвлөж байна.

а. Хоёр өвдгийг нь нийлүүлэлгүй, сандалд суулгах арга.

Сандалных нь голд зууван дугуй зөөлөвч тавьж өгөх Зураг.

Суухад түнхний үе, өвдөгний үе, шагайны үеийн хооронд тэгш өнцөг үүсгэсэн байх.

Хөлний ул нь шаланд гүйцэд хүрч байх



Зураг 25




Зураг 26

б. Мордож суух зориулалтын сандалыг гар аргаар хийж сурцгаая.


Суухад хөлний ул нь шаланд гүйцэд хүрч байх

Сүүний савнуудыг нийлүүлж хийнэ (а)

Мөн лааз ашиглаж болно. Өнгөн хэсгийг нь эсгийгээр бүрэх, зөөлөвч тавих зэргээр суухад эвтэйхэн болгоно. (b)



а.



б.



с.



д.

Сүүний савнуудыг  
нийлүүлж хийсэн сандал

Зураг 27


## 5. Юм түшиж зогсох болон бусдын тусламжтайгаар алхах үед анхаарах зүйлс

Юм түшиж зогсоход хүүхэд өлмийдөж гишгэдэг бөгөөд үүнээс болж хүүхдийн хөлний хэлбэр алдагдах, шагайны үеэрээ гадагшаа эсвэл дотогшоо эргэх гээд олон сөрөг үр дагавартай.

Зураг (а) 1) Өсгийг нь буулгаж шаланд хүргэж өгөх

(б) 2) Өсгийг нь буулгаж өгсөн ч шаланд хүрэхгүй бол өсгий доор эсгий алчуур зэргийг дэвсэж биеийн жинг нь хөлийн уланд жигд хуваарилах нь зохистой


(с) 3) Гутал өмсгөх тохиолдолд, хүүхдийн хөл нь гутлынхаа уланд бүрэн хүрч байхуйцаар өсгийд нь өндөрлөгөө хийж өгнө. Хүүхдийн гутал нь хөлийн шагайнаас дээш татсан хагас урт түрийтэй байна.



Зураг 28



Зураг 29



Зураг 30


(б) Бусдын тусламжтайгаар алхдаг боловч өсгийгөө өргөж явдаг хүүхдийн хувьд

Өсгийгөө өргөж алхаснаар Ахилын шөрмөс нь чангарч таталдан, хөл нь дотогшоо эргэж бүрмөсөн хэлбэрээ алддаг.

Тиймээс дараах зүйлсийг анхаарах нь чухал

1. Хүүхдийнхээ өсгийг газарт гүйцэд гишгүүлэхийн тулд удаан, аажим алхуулах дасгал хийлгэх
2. Өсгий нь огт газар хүрэхгүй бол а- 3) хагас урт түрийтэй гутал өмсгөн, өсгийд нь өндөрлөгөөтэй улавч хийж өгөх
3. Зориулалтын туслах хэрэгсэл, ортозын тусламжтайгаар хүүхдийн өсгийг гутлын уланд нь хүрч байхаар тааруулан хийлгэж хэрэглэх нь илүү үр дүнтэй бөгөөд ганцаараа бие даан алхдаг болж ч магадгүй юм.

**Анхаар:** Зориулалтын туслах хэрэгсэл, ортоз нь хүүхдийн хөлд таарсан хэмжээтэй байсан ч гэсэн, хүүхдийн чангарал, таталтын онцлогоос нь хамаараад алхаж, гишгэх үед нь хөлийг нь холгох, эмгэг хөдөлгөөнийг нэмэгдүүлэх, тэнцвэрийг нь алдагдуулах гээд олон сул тал илэрч болох тул заавал мэргэжлийн хөдөлгөөн засалчид үзүүлж зөвөлгөө аваарай.



Зураг 31



Зураг 32



Зураг 33

## 6) “Сунгалтын дасгалын зөв, тасралтгүй хийх нь хамгийн чухал”

- Хүүхдийн хөл чангаралттай бол газар суулгахад нуруу нь нумарч, өвдөг нь нугалардаггүй. Энэ нь өвдөгний арын булчин нь чангарч, хатуурсантай холбоотой.
- Хүүхдийг түшиж зогсоход, өлмийгөөрөө гишгэж, өсгийгөө өргөдөг. Энэ нь Ахилын шөрмөс нь хатуурч, богиноссонтой холбоотой юм.
- Хүүхэд насанд биеийн өсөлт хөгжил хамгийн идэвхитэй явагддаг. Хөлийн яс нь аяндаа хөгжиж, томорч байдаг боловч, ясыг нь даган байрласан булчин, шөрмөс нь мөлхөх, зогсох зэрэг хөдөлгөөн хийхгүй бол хөгжил нь хоцорч, ясныхаа хөгжлийг гүйцэхгүй болдог. Үүнээс болоод хүүхдийн өвдөг нь тэнийхгүй, үений хэлбэр нь эмгэг байдалд шилжих зэрэг хүнрэл үүсдэг.



Зураг 34



Зураг 35

<Хүндрэл үүсэхээс нь өмнө өвдөгний арын булчин болон Ахилын шөрмөсний сунгалтын дасгалыг өдөр бүр хийж хэвшицгээе>

Хийх арга: Өвдөгний арын булчингийн сунгалтын дасгал

Түнхний үеийг 90 хэм өнцөг үүсгэхээр нугалаад өвдгийг нь аажмаар тэнийлгэнэ

Хүүхдийг дээш харуулан хэвтүүлээд, эсвэл тэвэрч байгаад, сандал дээр суулгаж байгаад энэ дасгалыг хийлгэх боломжтой.

Сунгалтын дасгалыг нэг удаад 5 секундээр 8 удаа давтан хийгээрэй.



Зураг 36  
1-2 настай хүүхдэд



Зураг 37  
3-аас дээш насны хүүхэд

Хийх арга: Ахилын шөрмөсний сунгалтын дасгал

- Дасгалын хийхийн тулд эхлээд хүүхдийн өвдгийг тэнийлгэсэн байх
- Хүүхдийг хэвтүүлж байгаад, эсвэл тэвэрч байгаад, сандал дээр суулгаж байгаад энэ дасгалыг хийлгэх боломжтой.
- Хөлийн шагайны үеэр нь нугалж 5 секунд байлгана. Буцааж тэнийлгээд, дахин нугалах маягаар 8 удаа давтан хийнэ.
- Ахилын шөрмөс нь маш хатуу, хэт чангаралттай бол хүүхдийн өвдгийг тэнийлгэлгүй, өвдөгний үеэр нь бага зэрэг нугалж байгаад сунгалтын дасгалыг хийгээрэй. Дасгалын үр дүнд аажимдаа шөрмөс сунаж, өвдгийг нь тэнийлгэж хийх боломжтой болдог.



Зураг 38

## Энэхүү гарын авлагад орсон мэргэжлийн үг хэллэгийн тайлбар

Тархины саажилтын төрлүүд

1. Спастик хэлбэрийн ТС: Хөл гарын булчин нь хатууран чангарч, үенүүдээ чөлөөтэй хөдөлгөх боломжгүй болсон байдаг бөгөөд, өөр хүмүүс үеэр нь хөдөлгөх гэж оролдоход, ялангуяа хөдөлгөж эхлэх үед их эсэргүүцэлтэй тулгарна
2. Атетоз буюу эмгэг хөдөлгөөнтэй хэлбэрийн ТС: (\*1) Хөл гараа хөдөлгөх үед нь өөрийн хяналтгүй ухамсарт бус хөдөлгөөн хийдэг хэлбэр бөгөөд булчингийн тэнцвэрт байдал нь чанга, сул янз бүр байдаг
3. Хипотониа буюу булчингийн сулралтай хэлбэрийн ТС: (\*2) Ховор тохиолддог хэлбэр бөгөөд хүүхдийн гар хөлийн булчин хөгжөөгүй, үлбэгэр сул байдаг. Энэ нь хүүхэд томроход буюу 18-аас дээш сартай болох үед атетоз болон бусад хэлбэр болон өөрчлөгдөх нь бий.
4. Толгойгоо удирдах: Толгойгоо даадаг
5. Булчингийн татанхайрал: Булчин нь зангирч хатууран, үений хөдөлгөөний далайц хязгаарлагдсан байдал
6. Чангаралт: Тархины төвийн мэдрэлийн гэмтлээс шалтгаалан үүсдэг булчингийн эмгэг чангарал.

**Ашигласан материал:** Тархины саажилттай хүүхдийн гэрийн асаргаа 2-р дэвтэр  
*Зохиогч Nancie R.Finnie*

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргааны шинэ чиг хандлага  
*Зохиогч Имагава Тадао (хөдөлгөөн засалч)*

**Монгол хэлнээ хөрвүүлсэн**  
*М.Баяржаргал*  
2014 он